



НИЙСЛЭЛИЙН БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 19 өдөр

Дугаар А/103

Улаанбаатар хот

Г Газар эзэмших, ашиглах эрхийн дуудлага худалдаа зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5.3, 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт, 2020 оны 152 дугаар тогтоол, Барилга хот байгуулалтын сайдын 2018 оны 208 дугаар тушаал, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны А/40 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дүүргийн 2023 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан 6 байршлын 6 нэгж талбарт газар эзэмшүүлэх, ашиглуулах эрхийн нээлттэй дуудлага худалдааг 2023 оны 06 дугаар сарын 23-ны өдөр цахим хэлбэрээр зохих журмын дагуу зохион байгуулсугай.

2. Дуудлага худалдаагаар эзэмшүүлэх, ашиглуулах газрын байршил, зориулалт, хэмжээ, анхны үнийг хавсралтаар баталсугай.

3. Газар эзэмшүүлэх, ашиглуулах эрхийн нээлттэй дуудлага худалдааг зохих журмын дагуу зохион байгуулахыг Багахангай дүүргийн Газар зохион байгуулалтын алба (Ч.Магадсайхан)-нд үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч (Б.Болормаа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

АЖИЛ 2023 он ажил захирамж

1123000301

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
 2023 оны ... дүгээр сарын ... ны өдрийн
 ... дугаар захирамжийн хавсралт

ЦАХИМ ХЭЛБЭРИЙН ДУУДЛАГА ХУДАЛДААГААР ЭЗЭМШҮҮЛЭХ,
 АШИГЛУУЛАХ ГАЗРЫН БАЙРШИЛ, ЗОРИУЛАЛТ, ХЭМЖЭЭ, АНХНЫ ҮНЭ

№	Эзэмшүүлэх, ашиглуулах газрын байршил	Зориулалт	Газрын хэмжээ (м2-аар)	Газрын анхны үнэ (төгрөг)	Дэнчингийн төлбөр 10% (төгрөг)
1.	БХД 1-р хороо, Өндөртолгой	Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор	792	950.400	95.040
2.	БХД 1-р хороо, Өндөртолгой 6 байрны зүүн талд	Авто машины засвар, үйлчилгээний газар	300	360.000	36.000
3.	БХД 2-р хороо, Багахангай Багануур чиглэлийн төмөр замын урд, Улсын чанартай авто замын баруун талд	Үйлдвэрлэлийн барилга байгууламж, бусад газар	100000	36.000.000	3.600.000
4.	БХД 1-р хороо, Үйлдвэрийн бүсэд	Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор	404	484.800	48.480
5.	БХД 1-р хороо, Үйлдвэрийн бүсэд	Үйлдвэрлэлийн барилга байгууламж, бусад газар	20000	9.600.000	960.000
6.	БХД 1-р хороо, Үйлдвэрийн бүсийн баруун талд	ХАА-н үйлдвэрлэлийн цогцолбор	11600	5.568.000	556.800